



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

“Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК-ийн
хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 41.1, Хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдан 2014 оны 76 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ын 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК-ийн гаргасан 12 сарын хугацаатай 1,500,000,000.0 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай өрийн бичгийг бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмаар хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг “Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК /Ц.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000127